



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 116

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэг, Зохицуулах хорооны даргын 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/74 дугаар тушаалаар байгуулагдсан “Телевизийн газрын дахин дамжуулах сүлжээнд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох” сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн нэгдсэн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-ыг “Телевизийн газрын дахин дамжуулах сүлжээнд радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт”-д шалгарсанд тооцсугай.
2. Шалгарсан Радио телевизийн үндэсний сүлжээ УТҮГ-т радио давтамжийн зурвас хуваарилах саналыг 14 хоногийн дотор хорооны хуралд танилцуулж шийдвэрлүүлэхийг Радио давтамжийн зохицуулалт, хяналтын газар /З.Амгалан/- т даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР